БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МХГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БУА-2020-122-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Булган аймаг<br>2020 он | Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр<br>Утас: 70342580 Цахим хаяг:<br>Аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг:<br>Ахлах аудитор: П.Мөнхтуяа<br>Утас: 70342716 Цахим хаяг: |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсонүгийнжагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

Агуулга

**Аудитын гэрчилгээ** ........................................3
Аудитын тайлан........................................5
2.1. Оршил ........................................5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ........................................5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ........................................5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ........................................6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ........................................7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ........................................7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ........................................7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ........................................8
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга........................................9
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн........................................9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ........................................10
2.13. Шилэн дансны мэдээлэл ........................................10
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**Error! Bookmark not d**
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл........................................10
Менежментийн захидал ........................................10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан ........................................12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан........................................12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........................................12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан........................................16
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........................................20
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан........................................21
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан........................................25

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.01.28 № 13

танай ______________-ны №________________т

АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН
ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Б.БАТБОЛД ТАНАА

## Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дунд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

## 2.1. Оршил

Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг байгууллагын дарга Б.Батболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохоор Төсвийн тухай хууль, ЗГ-ын 184 дүгээр тогтоол, НББ-ийг мөрдөж ажиллахаар зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудитхийхүндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу МХГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

МХГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 27-ноос 2020 оны 01 дүгээр сарын 29–ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа хариуцан хэрэгжүүлэв.

МХГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 01/26 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитадмөрдсөнбодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

**2.4. Байгууллагынзорилго,үйлажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Булган аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь Булган аймгийн нутаг дэвсгэрт хууль тогтоомжийг сахиулан, хүний болон нийгмийн тогтвортой хөгжил, бизнес эрхлэх таатай орчинг дэмжиж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэхэд мэргэжлийн хяналтын байгууллагын эрхэм зорилго оршино.,эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэлээр дараах зорилтуудыг тодорхойлж ажиллажээ.
Үүнд:

- Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах ажлыг өргөжүүлэх
- Ард иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх
- Иргэдийн сэтгэлд хүрч итгэлийг дааж ажиллах
- Эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг илүү оновчтой болгох
- Хяналт шалгалтыг нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглүүлж үр дүнд хүргэх гэсэн зорилтуудын хүрээнд үйл ажиллагааг явуулсан байна.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Ажлын төлөвлөлтийг жил, улирал, сар, 7 хоногоор гарган гүйцэтгэлийг хангуулан тооцож, өдрийн бүтээмжийн үнэлгээ хийж, дэлгэмэл хүснэгтээр ажлын үзүүлэлтийг ил тод дүгнэж ирлээ.

Болзошгүй эрсдэл аюулаас урьдчилан сэргийлэх, объектоо бүрэн судлахад түлхүү анхаарч, эрсдэлийн үнэлгээн дээр 14 ажилбараар бүтээлчээр ажиллан эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, хоёр урсгалт харилцаа мэдээллийн сүлжээг хөгжүүлэх, эрсдэлийг бууруулж, үр дүн гаргахаар шинэлэг бөгөөд загвар болохоор ажил зохион байгуулсан.

Хоёр урсгал бүхий харилцаа мэдээллийн сүлжээгээр байгууллага, аж ахуйн нэгжээс хууль тогтоомж, стандартын талаар зөвлөмж, тусламж авахаар улсын байцаагч руу хандсан урсгалыг дэмжиж төлөвшүүлэхээр ажиллаж байна.

Хэрэглэгч, бизнес эрхлэгчид хуулийг сайн дураар сахин биелүүлэх соёлыг хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр Аймгийн ажил олгогч эздийн холбоо, Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим, бизнес эрхлэгчидтэй хамтран тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Угтах үйлчилгээний вэб сайтыг дотоод сүлжээнд холбох ажил хийгдсэн.

“Иргэн төвтэй үр дүнд чиглэсэн төрийн үйлчилгээг төлөвшүүлэх” жилийн ажлын хүрээнд Булган, Рашаант, Баяннуур, Дашинчилэн, Гурванбулаг, Бүрэгхангай, Хишиг-Өндөр, Могод, Орхон, Сайхан, Баян-Агт, Хутаг-Өндөр, Тэшиг, Бугат, Хангал, Сэлэнгэ сумд, Хялганат тосгон буюу нийт суманд 700 гаруй иргэнийг хамруулж зохион байгуулсан уулзалтаар байгууллагын үйл ажиллагааны чиглэл, хяналт шалгалтын талаар мэдээлэл хүргэж, гарч байгаа зөрчил дутагдал түүнийг арилгах арга зам, цаашид анхаарах асуудлыг ярилцаж, иргэдээс санал, асуумжийг авч байгууллагын цаашдын үйл ажиллагаанд тусган ажиллаж байна.

“Угтах үйлчилгээ” бий болгож, хуваарийн дагуу албан хаагчид угтах үйлчилгээнд ажиллаж байна. Үйлчлүүлэгчид вэб сайтыг ашиглах боломжийг бүрдүүлэн өгөгдлийг бий болгон программчилж эхэлсэн ба аж ахуйн нэгж, иргэдэд зориулж 105 ширхэг зөвлөмжийг өнгөтөөр гарган угтах үйлчилгээгээр хүргүүллээ.

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

МХГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Интерактив” програм хангамж ашигладаг байна.

МХГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар МХГ-ын 2019 онд бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн материаллаг түвшинг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүнг 274125.9 мянган төгрөгөөс тооцон 5482.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 11620.4 мянган төгрөгөөр тооцсон нь нийт хөрөнгөөс өндөр үзүүлэлтэй байгаа тул нийт зардлын 2 хувиар тооцсон болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

МХГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 260540.0 мянган төгрөгөөр буюу 8.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 66803.2 | 62069.1 | -4734.1 |
| Үндсэн хөрөнгө | 207450.9 | 238239.1 | 30787.2 |
| **Нийт хөрөнгө** | 274254.2 | 300308.2 | 26054.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 274254.2 | 300308.2 | 26054.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 274254.2 | 300308.2 | 26054.0 |

Оны эхэнд авлагын үлдэгдэлгүй тухайн онд авлага үүсээгүй байна.

Бараа материалын дансны 66803.3 мянган төгрөгийн үлдэгдэл дээр төсвийн хөрөнгөөр 30981.1 мянган төгрөгийг худалдан авч өссөн нь тухайн жилд байгууллагад шаардлагатай бараа материалыг худалдан авч нэмэгдүүлсэн, буурсан шалтгаан нь 33148.4 мянган төгрөгийг материал зарцуулж хуучирсан болон цаашид ашиглахгүй боломжгүй болсон 2566.9 мянган төгрөгийн материалыг байгууллагын даргын материал актлаж данс бүртгэлээс хасах тухай тушаал шийдвэрийн дагуу хасаж тайлагнасан байна.

Оны эцэст бараа материалын нөөц үүсгэсэн худалдан авалт хийгдээгүй батлагдсан төсвийн хуваарийн дагуу сар бүр материалын худалдан авалтыг хийж зарцуулалтаар тайлагнажээ.

Бараа материалын дансанд 2019 оны хөрөнгө оруулалтаар болон харьяа байгууллагууд болон захиалагч байгууллагад шилжүүлж авсан бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь төсвийн хөрөнгөөр 3570.7 мянган төгрөгийн, МХЕГ-аас 3329.3 мянган төгрөгийн, ТӨБЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 460 дугаар тогтоолоор элэгдэл нь дууссан хөрөнгийг дахин үнэлгээнд хамруулж 58750.0 мянган төгрөгийн хөрөнгийн анхны өртгийг нэмэгдүүлж нийт 65650.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгийг нэмэгдүүлснээр тайлагнасан нь байгууллагад нэн тэргүүнд шаардлагатай байгаа хөрөнгийг хандив тусламж болон төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн байна.

Үндсэн хөрөнгө буурсан шалтгаан нь цаашид ашиглах боломжгүй, эвдэрсэн, элэгдлээ бүрэн нөхсөн, ашиглах боломжгүй болсон 16 төрлийн 15148.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг ТӨБЗГ-ын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 533 тогтоолын дагуу акталж тайлан бүртгэлээс хасаж тайлагнасан байна.

Энэ онд хөрөнгө оруулалтаар хөрөнгө нэмэгдээгүй байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгөөс акталж хасагдсан хөрөнгө байхгүй болно.

Биет бус хөрөнгийн дансанд 51940.0 мянган төгрөгийн хөрөнгө тухайн онд өсөж буурсан үзүүлэлтгүй байна.

Өр төлбөр энэ онд өсөж буурсан үзүүлэлт байхгүй өр төлбөрийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Урт хугацаат өр төлбөр үүсээгүй болно.

Бусад өр төлбөр үүсгээгүй ажилласан нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллажээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 300308.2 мянган төгрөг болж 26054.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр болон хандив тусламжаар хөрөнгө нэмэгдүүлж байгууллагад шаардлагатай хөрөнгө бэлтгэж ажилласан байна.

Энэ нь байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдах, ажилчдын ажлын бүтээмж нэмэгдэх болно гэж үзэж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга бичилттэй холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар МХГ нь тайлант онд 5000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 7177.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 30 хувиар биелүүлсэн байна.

*Хүснэгт 2.* Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны буюу лабораторийн шинжилгээний орлого | 5000.0 | 7177.8 | 2177.8 | 30 |
| **Нийт дүн** | | | | |

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрт зорилт болон үйл ажиллагаанд зориулан 527685.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 524114.4 мянган төгрөгийг урсгал зардалд, 3570.7 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 527685.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 5000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулахад улсын төсвөөс 532685.1, ОБГ-аас 6981.1, НДС-аас 1824.8, үндсэн үйл ажиллагааны орлогоос 7177.8 мянган төгрөгийн орлого буюу нийт 548668.8 мянган төгрөгийн орлогын санхүүжилт авч гүйцэтгэлээр 514299.3 мянган төгрөг буюу 96.5 хувийг зарцуулснаар тайлагнаж төсвийн хэмнэлт 27251.7 мянган төгрөг дээр өөрийн үйл ажиллагааны орлого 7117.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж ажиллажээ.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулахад батлагдсан төсөв хуваарийн дагуу зарцуулж төсвийн хэлбэлзлийн дагуу тайлагнасан байна. Төсвийн хэлбэлзлээр цалингийн зардлаас 21439.8, НДШ-ийн зардлаас 2039.3, гэрэл цахилгааны зардлаас 1964.1, цэвэр бохир усны зардлаас 481.1, хоолны зардлаас 744.8, эмийн зардлаас 985.6 мянган төгрөг тус тус хэмнэгдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 514299.3 мянган төгрөг буюу 96.5 хувийг эзэлсэн нь цалин, НДШ, гэрэл цахилгаан, эм, хоол гэсэн бодит гарсан зардлын гүйцэтгэлээр гарсан төсвийн үлдэгдэл гэж үзэж байна.

**Нэмэлт төсөв:** Нэмэлт дансаар аймгийн ОБГ-аас шүлхий өвчний үед ажилласан ажилчдын томилолтын зардал болох 6981.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс томилолтын зардалд 6891.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

## 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 9 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 9 эрсдэл тодорхойлж нийт 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 16284.3 мянган төгрөгиийн алдаа, зөрчил илэрч давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

## 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Аймгийн МХГ нь 2019 оны байдлаар ажилчдад олгох ур чадварын нэмэгдэл болон үр дүнгийн урамшууллыг олгохдоо тушаал шийдвэр, чиглэлийн дагуу олгоогүй 40 хэтрүүлэн тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1, МХЕГ-ын чиглэлийн баримталж ажиллаагүй байна. Мөн ажилчдад олгох ур чадварын нэмэгдлийг байгууллагын даргын тушаал, шийдвэргүй сар бүр бодож олгосон, ур чадварын нэмэгдлийн тушаал гаргахдаа улирлаар нь олгох тухай тушаал гаргаж ажилласан зөрчил илэрснийг авч үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

## 2.13. Шилэн дансны мэдээлэл

МХГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан заасан мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлж ажилласныг нийцлийн аудитаар үзэх болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Итгэл”-д хамрагдсан болно.

## 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид МХГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

МХГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1. Үндсэн хөрөнгө*

*Илрүүлэлт:* Тус газар нь үндсэн хөрөнгийн бүртгэлд Land cruiser маркын 4460 хөдөлгүүрийн багтаамжтай автомашиныг 2019 оны жилийн эцэст үндсэн хөрөнгийн тайланд орлого авч бүртгэж тайлагнасан боловч уг автомашиныг эвдрэлтэй шалтгаанаар ашиглаагүй байна. Дээрх автомашин нь ЗГ-аас тогтоосон цилиндрийн хэмжээнээс их багтаамжтай тул цаашид ашиглахгүй байхаар арга хэмжээ авч ажиллах.

*1.1 Эрсдэл:*

Байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдахгүй, төлөвлөсөн зардал дутагдах, өр, авлага нэмэгдэх.

1.2 *Өгсөн зөвлөмж:*

Төсвийн тухай хуулийн 6.4.1, ЗГ-ийн 184 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах.

1.3 *Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийн дагуу ажиллаж биелэлтийг тооцон хариу хүргүүлэх*

*2. Зардал*

*Илрүүлэлт:* Ажилчдад 2019 оны байдлаар 16284.3 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг сар бүр олгосон боловч ур чадварын нэмэгдэл олгох тушаал шийдвэрийг улирлаар гарган ажилласан.

Мөн жилийн эцсийн үр дүнгийн урамшууллыг тооцож олгохдоо МХЕГ-ын 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 01/3918 тоот албан бичгээр үр дүнгийн урамшуулал олгохдоо үндсэн цалингийн 40 хувиас хэтрүүлэхгүйгээр олгох тухай чиглэлийг мөрдөж ажиллаагүй, 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 10370.0 мянган төгрөгөөр үр дүнгийн урамшууллыг тооцон олгосон байна.

*2.1 Эрсдэл:* Төсөвлөсөн зардал дутагдах, дотоод хяналт сулрах.

*2.2 Өгсөн зөвлөмж:* НББ-ийн 13.7 дахь заалтыг мөрдөж тушаал шийдвэрийн дагуу ур чадварын нэмэгдэл болон үр дүнгийн урамшуулал тооцон олгож байх.

2.3 *Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийн дагуу ажиллаж биелэлтийг тооцон хариу хүргүүлэх*

*3. Бусад*

*Илрүүлэлт:* МХЕГ-ын даргын 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/171 тоот тушаалаар баталж боловсруулан ашиглаж байгаа НББББББ-ийн 39 дүгээр зүйлийн ЗГ-ын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ, 46 дугаар зүйлийн Төсвийн урамшуулал хэсэгт ТАТХууль шинэчлэгдсэнтэй холбоотойгоор өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

*3.1 Эрсдэл: Дотоод хяналт сулрах*

*3.2 Өгсөн зөвлөмж:* НББ-ийн тухай хуулийн 18.2 дахь заалтыг мөрдлөг болгох.

3.3 *Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийн дагуу ажиллаж биелэлтийг тооцон хариу хүргүүлэх*

*4. Бусад*

*Илрүүлэлт:* Тус газрын ашиглаж байгаа санхүүгийн программ нь ажиллагсдын цалингийн картыг тусад нь бодож хэвлэгддэггүй, нягтлан бодогч гараар цалинг шивж картлуулан ажилладаг байна. Иймд нягтлан бодох санхүүгийн программыг сайжруулан цалингийн программтай болох шаардлагатай байна.

*4.1 Эрсдэл:* Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа доголдох.

*4.2 Өгсөн зөвлөмж:* Сангийн сайдын 47 дугаар тушаалыг мөрдөж ажиллах
4.3 *Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийн дагуу ажиллаж биелэлтийг тооцон хариу хүргүүлэх*

**Мэдэгдэл:**

Аудитаар өгсөн 4 зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож 2020 оны 05 сарын 15-ны дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг мэдэгдье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

## 1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

МХГ **СТ-1А**

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **66803267.25** | **62069111.72** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 66803267.25 | 62069111.72 |
| **351** | **Түүхий эд материал** | 9835079.13 | 3554024.42 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 158050.00 | 158050.00 |
| 35130 | Эм боох материал | 9677029.13 | 3395974.42 |
| **354** | **Хангамжийн материал** | 56968188.12 | 58515087.30 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 762284.04 | 1059124.04 |
| 35420 | Аж ахуйн материал | 48490620.82 | 49359479.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 4084254.00 | 4432155.00 |
| 35450 | Барилгын засварын материал | | |
| 35460 | Хүнсний материал | | |
| 35470 | Бусад хангамжийн материал | 3631029.26 | 3664329.26 |
| 35500 | Биологийн хөрөнгө | | |
| 35600 | Мал амьтад | | |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **207450933.61** | **238239146.55** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 207450933.61 | 238239146.55 |
| 391 | Газар | | |
| **392** | **Биет хөрөнгө** | 156523933.61 | 187312146.55 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 70211220.00 | 65249310.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | 5329930.80 | 2816443.25 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 162979860.00 | 162979860.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | 102058148.73 | 114646077.93 |

| | | | |
|---|---|---|---|
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 286110833.16 | 333074495.16 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | 256045426.25 | 262802878.60 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 30567545.18 | 37217545.18 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | 29912018.95 | 30943664.01 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 50927000.00 | 50927000.00 |
| 39301 | Программ хангамж | 1013000.00 | 1013000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | 1013000.00 | 1013000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 50927000.00 | 50927000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **274254200.86** | **300308258.27** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **274254200.86** | **300308258.27** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 274254200.86 | 300308258.27 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 437965840.30 | 437965840.30 |
| 51101 | Өмч: - төрийн | | |
| 51102 | - хувийн | | |
| 51103 | - хувьцаат | | |
| 51104 | Халаасны хувьцаа | | |
| 51105 | Нэмж төлөгдсөн капитал | | |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | | |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -260186543.72 | -228122616.31 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -206611649.64 | -254176673.72 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -53574894.08 | 26054057.41 |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | | |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 96474904.28 | 90465034.28 |
| 51400 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | |
| 51500 | Бодлогын өөрчлөлт алдааны залруулга | | |
| 51600 | Нөөцийн сан | | |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **274254200.86** | **300308258.27** |

### 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

МХГ **СТ-2А**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **576119601.00** | **607074020.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **32330931.00** | **67407800.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 32330931.00 | 67407800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 32330931.00 | 67407800.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7304200.00 | 7177800.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 25026731.00 | 60230000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **543788670.00** | **539666220.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 540499900.00 | 532685100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 540499900.00 | 532685100.00 |
